

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Инноваци судалгаа, бизнес хөгжлийн төв бизнес хөгжлийн төв Улсын төсөвт
үйлдвэрийн газрын 2023 оны санхүүгийн тайлангийн хийсэн аудитын хураангуй
тайлан

Аудитын код: ГАА-2024/08/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn

Алтай хот

2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа

Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn

Ахлах аудитор: М.Атарцэцэг

Утас: 88984411 Цахим хаяг: atartsetsegm@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ГАА-2024/16/НА-СТА-ТШЗ



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинет баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13, Факс: 1976, 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.03.15 № 119

танай _____ -ны № _____ -г

ИННОВАЦИ СУДАЛГАА, БИЗНЕС
ХӨГЖЛИЙН ТӨВ УТУГ-ЫН
ЗАХИРАЛ Т.ЭРХЭМБАЯР ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Инноваци судалгаа, бизнес хөгжлийн төв Улсын төсөвт үйлдвэрийн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, үр дүнгийн тайлан, цэвэр өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийг эс зөвшөөрвөл Инноваци судалгаа, бизнес хөгжлийн төв бизнес хөгжлийн төв Улсын төсөвт үйлдвэрийн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны , 77 дугаар тогтоолоор баталсан эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн төлөвлөсөн зардлыг хэтрүүлэн зарцуулсан 10,543.7 мянган төгрөгийн зөрчил нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дах заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

Асуудлыг онцолсон хэсэг

Инноваци судалгаа, бизнес хөгжлийн төв нь инновацыг хэрэглээнд нэвтрүүлж, эдийн засгийн үр ашиг, өрсөлдөх чадвар, бүтээмжийг дээшлүүлэн нийгмийн үйлчилгээг сайжруулах зорилготой байгуулагдсан боловч тайлант онд "Хантайшир уулын аймаг-100" жилийн маркетингийн график, дизайныг гаргаж, цахим хэлбэрээр тухайн үйл ажиллагааны мэдээллийн танилцуулга хийж, мэдээ, мэдээллийг түгээж ажилласан байна.

0702700398

Аудитын гол асуудал

Тус төвийн чиг үүргийг бусад төрийн байгууллагатай давхардуулалгүйгээр оновчтой зохион байгуулж ажиллах шаардлагатай байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 9 зорилт, 45 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 35 арга хэмжээг бүрэн, 5 арга хэмжээг 90.0 хувь, 5 арга хэмжээг 80.0 хувьтай биелүүлж нийт дүнгээр 96.0 хувиар үнэлэгдсэн байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/мян.төгрөгөөр/

Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	67,088.8	13,672.5
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	61,123.9	48,235.4
Нийт хөрөнгийн дүн	128,212.6	61,908.0
Нийт өр төлбөрийн дүн	-	-
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	128,212.6	61,908.0
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	128,212.6	61,908.0
Үйл ажиллагааны орлогын дүн	238,600.0	277,452.2
Үйл ажиллагааны зардлын дүн	201,487.0	343,756.9
Үйл ажиллагааны үр дүн	37,113.0	(66,304.7)
Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
Үйл ажиллагааны нийт үр дүн	37,113.0	(66,304.7)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	128,212.6	61,908.0
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	91,099.7	128,212.6
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-
Тайлант оны үр дүн	37,112.97	(66,304.7)
Эцсийн үлдэгдэл	128,212.6	61,908.0
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	238,600.0	277,452.2
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	189,596.02	330,374.60
Үйл ажиллагааны ЦМГ	49,004.0	(52,922.4)
Хөрөнгө оруулалтын ЦМГ	-	(2,000.0)
Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	49,004.0	(54,922.4)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	26,000.3	62,363.3
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	62,363.3	7,440.9
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	229,629.2	332,374.6
Урсгал зардал	229,629.2	332,374.6
Хөрөнгийн зардал	-	-
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	245,629.2	277,333.4
Улсын төсвөөс санхүүжих		
Орон нутгийн төсвөөс санхүүжих	225,629.2	245,298.6
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	20,000.0	32,034.8
Үндсэн үйл ажиллагааны ашиг /алдагдал/	16,000.0	(55,041.2)

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитын илрүүлэлт

Залруулагдаагүй 10,543.7 нийт мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 10,543.7 мянган төгрөгийн 2 зөрчил¹ илэрч 1 зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага, 1 зөрчилд зөвлөмж өгсөн.

5.1 Албан шаардлага

1. Байгууллагын 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөсөн зардлыг 10,543.7 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь заалт /үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах/, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 77 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт"-тай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөгөөр баталсан зардлын хүрээнд хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар зарцуулах албан шаардлага хүргүүлсэн.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас төрийн албан хаагчдад орон нутгийн цалингийн нэмэгдэл олгох шийдвэр гаргасны дагуу 24,855.2 мянган төгрөгийн цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал нэмэгдсэн байна. Байгууллагын 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түшингийн төлөвлөгөөнд өөрчлөлт оруулан эрх бүхий байгууллагаар шинэчлэн батлуулаагүй нь “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20.3-т “Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах,”Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь заалт /үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах/, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 77 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт"-тай нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Зохих байгууллагаас баталсан эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг бүрэн биелүүлж, баталсан зардлын хүрээнд хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэйгээр зарцуулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	/мянган төгрөгөөр/							
	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Байгууллагын 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөсөн зардлыг 10,543.7 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.	1	10,543.7	-	-	1	10,543.7	-	-
Аймгийн ИТХ-аас төрийн албан хаагчдад орон нутгийн цалингийн нэмэгдэл олгох шийдвэр гаргасны дагуу 24,855.2 мянган төгрөгийн цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал нэмэгдсэн байна. Байгууллагын 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түшингийн төлөвлөгөөнд өөрчлөлт оруулан эрх бүхий байгууллагаар шинэчлэн батлуулаагүй байна.	1	-	-	-	-	-	1	-
Дүн	2	10,543.7	-	-	1	10,543.7	1	-

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	/мянган төгрөгөөр/							
	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлогын 31,194.8 мянган төгрөгийн 3, зарлагын 5,400.0 мянган төгрөгийн 1 гүйлгээг мэдээлээгүй.	1	-	-	-	-	-	1	-
Дүн	1	-	-	-	-	-	1	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн	-	-	-	-	-	-	-	-
Нийт дүн	1	-	-	-	-	-	1	-